



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 1/362

Мандалговь

Газар эзэмшүүлэх хэмжээ
өөрчлөх тухай

Монгол улсын Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйл 21.3.2 дах заалт, 2013 оны Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын 21 дүгээр зүйлийн ХХ.1.43 дахь хэсэг, Засгийн газрын 2009 оны 25 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Монгол улсын 2013 оны Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын 21 дүгээр зүйлийн ХХ.1.43 дахь хэсэгт тусгагдсан "Газрын кадастрын мэдээллийн сан"-г солбицлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх ажлын хүрээнд "Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах, геодезийн солбицол, өндөр тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, турших, нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх" ажил хэрэгжсэнтэй холбогдуулан нэгдүгээр хавсралтанд дурьдсан 4 иргэнд 2102 м.кв /0,2га/, хоёрдугаар хавсралтанд дурьдсан 3 байгууллагад 18173 м.кв/ 1,8 га/ газрыг тус тус эзэмшүүлсүгэй.

Хоёр. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан хавсралтанд заасан аймгийн Засаг даргын захирамжийн холбогдох хэсгийг мөн газар эзэмших гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Гурав. Дээрх иргэн, байгууллагатай газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Э.Чагнаадорж/, гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Сайнцагаан сумын Засаг дарга, хотын захирагч /Р.Мөнхтогтох/, аймгийн Мэргэжлийн хян алтын газрын дарга /Ш.Төрбат/ нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ



0200967

